



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Г Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 12 сарын 8-ны өдрийн 318 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний түргэн тусlamжийн сүлжээ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. “Үндэсний түргэн тусlamжийн сүлжээ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Эрүүл мэндийн сайдын зөвлөлд жил бүр танилцуулахыг зохицуулах зөвлөлийн дарга /Ж.Амарсанаа/-д даалгасугай.



001691

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
15 сарын 15 өдрийн 49 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

88

“ҮНДЭСНИЙ ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН СҮЛЖЭЭ ХӨТӨЛБӨР”-ИИН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Эрүүл мэндийн дэд сайд
Дэд дарга: Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн яаралтай,
түргэн тусlamжийн сүлжээний зохицуулалтын албаны дарга

Гишүүд: Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн
дарга

Эрүүл мэндийн яамны Оношлогоо, эмчилгээний технологийн
хэлтсийн дарга

Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн
дарга

Эрүүл мэндийн яамны Гадаад хамтын ажиллагааны
хэлтсийн дарга

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга

Эрүүл мэндийн яамны яаралтай тусlamжийн ерөнхий
мэргэжилтэн

Эрүүл мэндийн яамны яаралтай болон түргэн тусlamжийн
бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн

Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратеги
төлөвлөлтийн газрын салбарын хөгжлийн бодлого
зохицуулалтын хэлтсийн Эрүүл мэндийн салбар хариуцсан
мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Онцгой байдлын ерөнхий газрын Гамшигаас хамгаалах газрын
дарга /зөвшилцсөнөөр/

Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга

Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн дарга

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
02 сарын 15-өдрийн 49 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

89

“ҮНДЭСНИЙ ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН СҮЛЖЭЭ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “Үндэсний түргэн тусlamжийн сүлжээ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохицуулах зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих, эмнэлгийн яаралтай болон түргэн тусlamжийн хүний нөөцийн судалгааг гаргуулж, шийдвэрлэх арга хэмжээ авах, эмнэлгийн яаралтай, түргэн тусlamжийн шинэчлэлийн төсөлд олон улсын байгууллагын дэмжлэг авах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлогын зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий орон тооны бус бүтэц байна.

1.2 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь үндэсний түргэн тусlamжийн сүлжээний байгууллагуудын хүний нөөцийн чадавх, материаллаг баазыг бэхжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах замаар үндэсний хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэхэд оршино.

1.3 Зөвлөл нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичиг, энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1 “Үндэсний түргэн тусlamжийн сүлжээ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, хяналт тавих;

2.2 Холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, хяналт тавих;

2.3 Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бодлогын санал боловсруулах, зөвлөмж гаргах;

2.4 Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах;

Гурав. Зөвлөлийн бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1 Зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, ажлын албанаас бүрдэнэ.

3.2 Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид “ЭМХТ” гэх)-ийн Эмнэлгийн яаралтай, түргэн тусlamжийн сүлжээний зохицуулалтын алба нь Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх)-ны үүргийг гүйцэтгэнэ.

3.3 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байх ба хурлаас шийдвэр гарна. Шийдвэр нь тухайн хэлэлцсэн асуудалтай холбоотой санал,

дүгнэлт, зөвлөмж, тогтоол хэлбэртэй байх ба шийдвэрт Зөвлөлийн дарга гарын үсэг зурснаар хүчинтэйд тооцогдоно.

3.4 Зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

3.5 Зөвлөлийн гишүүдийн 70-с дээш хувийн ирцээр хурал хүчинтэйд тооцогдоно.

3.6 Хурлыг Зөвлөлийн дарга, түүний эзгүйд Дэд дарга даргална. Аль аль нь оролцох боломжгүй тохиолдолд хурлыг хойшлуулна.

3.7 Зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаанаар хуралд ирэхгүй тохиолдолд шалтгаанаа Зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргад хурал хуралдахаас 1 хоногийн өмнө мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа бичгээр ирүүлнэ.

3.8 Зөвлөлийн гишүүнийг өөр албан тушаалтнаар орлуулахгүй.

Дөрөв. Зөвлөлийн даргын чиг үүрэг

- 4.1 Зөвлөлийн хурлыг товлох, дэг, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлах;
- 4.2 Зөвлөлийн хурлаас гарсан санал, зөвлөмжийг баталгаажуулах;
- 4.3 Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
- 4.4 Зөвлөлийн үйл ажиллагааны жил тутмын санхүүжилтийн саналыг батлах;
- 4.5 Зөвлөлийн хурал даргалах;

Тав. Зөвлөлийн нарийн бичгийн даргын чиг үүрэг

- 5.1 Ажлын албыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах;
- 5.2 Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг боловсруулах, хурлын бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулах;
- 5.3 Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулах;
- 5.4 Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг гарган зөвлөлийн хуралд танилцуулах.

Зургаа. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

- 6.1 Зөвлөлийн нарийн бичгийн дарга Зөвлөлийн жил тутмын төсвийг боловсруулан, Зөвлөлийн даргаар баталгаажуулан ЭМЯ-ны жил бүрийн төсөөт тусгаж хэрэгжүүлнэ.